

**Д.Равжаагийн «Бясалгалын эгшиглэл оршвой» шүлгийн
герменевтик утга**

Нямын ГАНХУЯГ

Боловсрол судлалын магистр

Хураангуй: Д.Равжаагийн энэхүү шүлэг нь төвөд хэлээр зохиогдсоныг алдарт Төвөдөч Л.Хүрэлбаатар гуай 1987 онд орчуулж, Ил товчоо сонины хүсэлтээр хэвлүүлсэн бөгөөд энэ шүлэг нь яруу сайхан найруулгатай, гүн утга санаатай эгэл нэгэн санан бодож эргэцүүлмээр агуулгатай ажээ. Ноён хутагт шүлэгтээ өмнөх шүлэг найргийн мөрнөөс шигтгэж өгсөн бөгөөд хүний амьдралын бэрхшээл зовлонг хэрхэн даван туулах өөрийн сүсэг бишрэл, мөнх бус жам ёс, цаг хугацааг үр бүтээлтэй өнгөрүүлэх, учир утгатай амьдрахад дорнын их гүн ухаан тус дэм болно гэдгийг энгийн ойлгомжтой өгүүлсэн гайхамшигтай шүлэг болно.

Түлхүүр үг: багш, бурхан, хувраг, зовлон, жаргал, бие, хэл, сэтгэл, нөхөд,

Удиртгал: “Амь мэт нөхөд ч, ад мэт урвана”- мөнх бусын жам ёсны тухай өгүүлсэн.

Судалгааны арга: герменевтика, задлан шинжлэх

Судалгааны хэсэг

1 “Төвдөч эрдэмтэн доктор, профессор Л.Хүрэлбаатар агсан 5-р дүрийн догшин ноён хутагт Данзанравжаагийн төвд хэлээр зохиосон “Бясалгалын эгшиглэл оршвой” хэмээх шүлгийг шинээр төвдөөс монгол хэлрүү дуун хөрвүүлж, түүнд энэхүү хорвоогийн хоосон чанарыг “Үүлэн мэт арвидавч хоосорч оддог” хэмээн төвөд хэлнээс хосгүй урнаар шүлэглэн орчуулсныг, Ил товчоо сонины 1998 оны 12-р дугаарт хэвлэгдсэнийг судалгааны эргэлтэд оруулж байгаа бөгөөд энэхүү шүлэг удаа дараа хэвлэгдсэн түүвэр зохиолуудад хэвлэгдээгүй болно.

1. Аяа хохой, багш чухаг дээд айлд

Миний жаргал зовлонг айлдагчууд айлд

* © Н.Ганхуяг 2024

E-mail: nyamgankhuyag@gmail.com

Аяа хуран үүдсэн энэ үзэгдэл

Сэтгэлд бат үл болохын тул уйдмуй

2.Хорвоо ертөнцийн энэ орноо

Амгалан суухын үе нэг ч үгүй нь магадтай

Буй юм шиг, мөнх юм шиг үзэгдэн үзэгдсэнээс

Тэнгэр язгуурын энэ шүтээнийг огоорох шахамдвай

Эхний бадгуудад ерийн хүн, миний жаргал зовлонгийн учир шалтгааныг багш, ном, хуврагууд минь айлдаж хайрла, сэтгэл тогтворгүй, мөнх буй юм шиг энэ хорвоо ертөнцөд амгалан амьдрахын цаг нэг ч хором үгүй тул тэнгэр язгуурын багш, ном, хуврагаа мартах шахлаа хэмээн ихэд харамсан, алс хэтийн зөв замыг зааж өгнө үү хэмээн наманчлан хүсч байна. Д. Равжаа хутагт бээр хүний амьдралын бэрхшээл зовлонг хувь хүний сэтгэл зүйн талаас, бүх юмны учир шалтгаан сэтгэл оюуны үүднээс тайлбарлаж ирсэн нь ихээхэн дэвшилттэй шинэлэг санаа юм.

3.Энэ насны буурал, энэ баясгалангийн үзэгдэл

Солонго мэт үзэсгэлэн дуртавч замхарч одмуй

Луун дуу мэт нүргэлэвч буурч одмуй

Үүлэн мэт арвидавч хоосорч одмуй

\Мөнх бусын жам\

4.Энэ бие зээлийн байшин адил

\мөнх бусын шалтгаан\

Эцэст үлдэх ором магад үгүй

Нөхдүүд зүүдний үзэсгэлэнт эм адил

Өнөд нөхөрлөхийн эрх үгүй хагацмуй

5.Хүсэл эрдэм илбийн баясгалан адил

Зуун амтыг амсавч мартагдаж хоцормуй

Эдийг сахих нь нохой лугаа адил

Өөрөө үл эдлэн бусдын эдлэх эд агуурс

6.Орхиод явахын цагт бууваас

Энхрийлсэн энэ биеийг ч дэвсгэргүй орхимуй

Хаяад одохын цагт бууваас

Хаан ч, нөхөр ч хагацаад одмуй

7.Эрт нөгчсөн нөхдүүд хаана одсон

\жам ёсны жишээ\

Эдүгээ байгаа нөхөд лүгээ хэр удаан ханилах

Эгүүнийг үзсээр хэр нь үнэнд баримтлах

Эдүгээ би ер нь галзуу буюу юун

8.Хэзээ нэгнээ ганцаар одохын тэр цагт

Унгирал мэт зөөлөн бие, мод мэт хөшнө

Ус мэт мэлтэлзсэн нүд, шороо мэт хатна

Уул мэт овоолсон эд, тоос мэт барагдана

9.Амь мэт нөхөд ч, ад мэт урвана

Гал мэт бадравч, үнс мэт үлдэнэ
 Бурхан мэт залагдавч, гахай мэт мунхаглана
 Салхин мэт дуурссанууд солонго мэт арилна
 10.Ноён мэт суувч, нохой мэт тэнэмүй \мөнх бусын шалтгаан\
 Уул мэт бат ч, өд мэт хийсмүй
 Алт мэт хайрлавч, адасга мэт орхигдмүй

Аяа хохой, орчлон магадтай хуурамч хэмээн энэхүү ертөнцөд санасандаа хүрч, сайн сайхан амьдрах санааг илэрхийлж, хүн хорвоод 4 зүйлийн “ил өндрийг” олж, төгс жаргалтай амьдарна гэнэ. Үүнд биеийн ил өндөр, эд таваарын ил өндөр, нөхөр сэлтийн ил өндөр, бүтээл туурвилын ил өндөр эдгээр болно. Үүнийг бид хорвоогийн хүний тухайд юу гэж ойлгох вэ гэвэл юмыг хийж болох сайн биеийг олох, амьдралын хэрэгцээт эд агуурсаар дутагдахгүй байх, зөв талд дэмжлэг болох нөхөдтэй байх, ажил үйлийн эцсийг төгс бүтээх хичээлтэй байх дөрөв хэмээн доктор Л. Хүрэлбаатар тайлбарласан байдаг. Гэвч энэ бүхэн хорвоогийн жам ёсоор амьдрал, хувь хүний алба, ажил үйлс цаг хэмжээтэй, хувиран өөрчлөгдөж байдаг гэсэн санааг дээрх 3-10 бадгуудад өгүүлж, цаг хугацаатай уралдан, бүтээж туурвин, үүрд үлдэх хөдөлмөр, бүтээлийн төлөө цуцалтгүй ажиллаж, амжин бүтээхийг сануулан сургасан энгийн ойлгомжтой ятган сэнхрүүлсэн байна.

Сэтгэлийн чанарыг эс таниваас
 Амгалангийн цаг үгүй хэмээн Бурхан номловой
 Бүгд сэтгэлийг эс таньсны тул

Гурван аймаг сансар хорвоогийн балгадад тэнэвэй хэмээн сэтгэлийн мөн чанар, дотоод ухааныг зөв таньж мэдэхгүй бол бурхны гурван их аймаг савын ном болох 1.Бурхан багшийн сургаал-судрын аймаг сав \бурхан багшийн айлдвар, сургаал\, 2.Винайн аймаг сав \бурхан багшийн тогтоосон дэг сахилга\, 3.Авидармын аймаг сав \судрын болон винайн аймаг савд хожмын эрдэмтэд, бурхны зүтгэлтнүүдийн бичиж туурвисан тайлбар бүтээлүүд\ бурхан багшийн Трипитика хэмээхийг судлан, гэгээрвэл сансар хорвоод төөрөлгүй сайн сайхан явж, зөв амьдарна хэмээн бурхан багш номлосон гэдгийг дээрх бадгуудад тайлбарласан байдаг.

Зовлонг санахын цаг үгүй нь \жишээ шалгуур\
 Өвчинд эм нь буруудаж одсон мэт
 Эрхгүй үйлээр хагацах нь
 Шувууны өд салхиар туутдсан мэт \мунхаг\
 Хорлолыг тустайд эгээрэх нь
 Эрвээхэй зулын гэрэлд тачиях мэт \шунал\
 Бусыг мэнд сэтгэх нь
 Зэрэглээг усанд эндүүрэх мэт \мунхаглах\

Үгүйг буйд барих нь

Ханиа холд үхүүлсэн мэт
 Энэ насны үзэгдлийн хойноос нэхэх нь
 Өт хорхой идэшний мөрт гүйх мэт \ хилэгнэх\
 Өвөр бусдыг хоёрт барих нь
 Өчүүхэн нялхын толинд харсан мэт
 Хүсээгүй зовлонг эдлэх нь
 Галуу явсаар торонд орсон мэт \ атаархах\
 Өөрийн хийсэн үйл өөрт эргэх нь
 Үзгэл луус хээлтсэнээр үхэх мэт
 Сэтгэлийн бат итгэмж үгүй
 Хааны цааз буух мэт \ омог\
 Насад бусдыг сэжиглэх нь
 Хорт могойн уурласан нүд мэт \ уурлан хилэгнэх\
 Бурхныг бусдаас эрэх нь
 Балай сохор өөрийн эдээ эрэх мэт \ атаархан жөтөөрхөх\
 Үзэвч өөрийгөө эс таних нь
 Бич худаг руу харайсан мэт \ мунхаглан тэнэгрэх\
 Ухавч утгыг эс мэдэх нь
 Согтсоноор зуун амтыг амссан мэт \ шунан хүсэх\
 Эндүүрлийн үрийг амсах нь
 Өчүүхэн хөвгүүн үсний хутгаар тоглосон мэт \ уурлах\
 Хаана одох тэнд одохыг мэдэх үгүй нь

Харанхуй шөнө толгой эргэсэн мэт \мунхаг\ нисванисын таван хорноос ангид амьдрах\ хэмээн гүн ухааны ойлголтоор “нисванис” ньюмон, \nyon mongs\ гэдэг нь үзэгдэл юмыг үнэн бодитой өөрийн талаас бүтсэн хэмээх урин мунхаг, түүнээс уяатай урин хилэн, урин тачаангуй гурав юм. Энэ гурвын уршгаар ертөнцийн бүх хүний санаа сэтгэл сайжран дээшилж чадахгүй, хорвоогийн зовлонгийн үртэй, жаргалын амттай жимсийг амсаж идэж цадахгүй, хорвоод эргэж буцаж зовсоор байгааг гүн ухааны үүднээс тайлбарлаж болно. Дээрх бадгуудад хүний сэтгэл санааг тогтворгүй, амар амгалан байлгадаггүй нисванисын 5 хорноос ангид байж, өөрийн сэтгэлээ ариусгахыг өгүүлсэн байна.

Энэ мэт эндүүрлийн үзэгдэл дор
 Эгнэгт явагч би аяа хөөрхий
 Миний мэтийн бусад ч хөөрхий
 Өвөр бусдын тусад сэтгэлийг үүсгэх болой
 Сэтгэлийн эрдэнэ бодь сэтгэл
 Би түүнийг төрүүлэн үйлдмүй
 Миний багш Очирвани
 Бодь сэтгэлийг төрүүлэн адистэдлэ
 Амьтны тусад бурхны хутгийг

Аяа энэ насанд олох болтугай. гэсэн төгсгөлийн мөрүүдэд юмс үзэгдлийн мөн чанарыг хүний оюун ухаан, сэтгэлийн үүднээс тайлбарласан. Энэ бүхний үндэс нь би өөрөө энэ хорвоо ертөнцийн өнөөгийн хуурмаг амьдралаа мөнх юм шиг санаж, эндүүрч явснаа ойлгон, өвөр бусдын тусад өөрийгөө зориулах, амьдралын утга учир сэтгэлийн гагц чандмань эрдэнэ болсон бодь- энэрэнгүй сэтгэлийг өөртөө төрүүлэн үйлдэх нь хамгийн чухал гэдгийг ойлгож, үүнд минь бодь энэрэнгүй сэтгэлтэй болоход минь Очирвани багш минь атислан хайрла хэмээн гуйж, хамаг амьтны тусын тулд бурхны дээд хутгийг энэ насанд соёрхон хайрла хэмээн тунхагласан нь эдүгээ бидний үед ч өнөөдөр маргаашаа бодон алс хэтээ мартан зөв амьдралын төлөө бусдадаа тусалж, буян үйлдэж амьдрахыг сургамжилсан гайхамшигт сургаал ажээ.

Ийнхүү их сурган хүмүүжүүлэгч, гүн ухаантан, яруу найрагч, жүжгийн зохиолч Д.Равжаа энэхүү шүлэгтээ аливаа хүмүүнийг засан сайжруулах, ойлгон ухамсарлуулахад түүний сэтгэл, оюуныг гэгээрүүлэн сэнхрүүлэхээс эхлэх хэрэгтэй гэсэн санааг учир шалтгааны үүднээс яруу сайхан жишээ баримтаар ятган сэнхрүүлж, уриалан дуудсан гайхамшигтай бүтээл юм хэмээн үзэж байна.

Судалгааны үр дүн:

1.Шүлгийн гол утга санаа нь мөнх бус жам ёсны амьдрал, хоосон чанартай энэ дэлхийг хүний оюун сэтгэлийн үүднээс жаргал зовлон, сэтгэлийн тогтворгүй зан араншин, хүний урин шунал, уур хилэн, урин мунхгаас болдгийн гол шалтгаан болдгийг өгүүлсэн төдийгүй зовлон жаргалын үндэс нь сэтгэлийн амгалан байдал гээд түүнийг дорнын гүн ухааны үүднээс бодь сэтгэлийг өөртөө үүсгэснээр бурхны хутгийг олж амар амгалан болно гэсэн утгыг илэрхийлнэ.

2. Уран зохиолын яруу хэрэглүүр болох адилтгал, зүйрлэлээр яруу илэрхийлсэн. Эгэл хүмүүст зориулсан, цаг үе, өдөр тутмын амьдралын нугачаанд дарагдан, өөрийн бие, хэл, сэтгэлийн амар амгаланг алдагдуулдаг дотоод сэтгэлийн таван хор буюу шунал, мунхаг, уур, атаа, омог зэргийг ялан дийлж, өөртөө эзэн болж, өөрийн энэрэх сэтгэлээ эх эцгээ хайрлах мэт даган баясуулж, бусдын төлөө өөрийгөө зориулах тэр их үйлсийг дадуулбаас алдар нэр, амьдрал амгалан болж, асар их буяныг үйлдсэнээр хүн хэмээх хүнлэг энэрэнгүй чанараа хадгалж чадна хэмээн, хүн гэдэг ухаант насны хөсгөөрөө цаг хугацаатай уралдан бүтээж амьдрахыг учиртай уран яруу дүрслэх хэрэглүүрээр ой тойнд ортол амьдралын утга учрыг сэнхэртэл өгүүлсэнд энэхүү шүлгийн яруу дүрслэлээр дамжин илэрхийлэгджээ.

3.Сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын утга нь: “Сэтгэлд бат үл болохын тул уйдмуй”...“Сэтгэлийн чанарыг эс таниваас Амгалангийн цаг үгүй хэмээн бурхан номлавай.”... “Сэтгэлийн бат итгэмж үгүй нь Хааны цааз буух мэт” ...Миний мэтийн бусад хөөрхий Өвөр бусдын тусад сэтгэлийг үүсгэх болой Сэтгэлийн эрдэнэ- бодь сэтгэл Би түүнийг төрүүлэн үйлдмүй”... “Миний багш Очирвани Бодь сэтгэлийг төрүүлэн атистэдлэ Аяа энэ насанд олох болтугай”

хэмээн хүн өөрөө өөрийн сэтгэлээ удирдан, төгс ухамсар сэтгэлтэй хүн болохыг учир шалтгааны үүднээс тайлбарласан. Хүн өөрөө өөрийнхөө бурхан, хүнд өөрт нь сайн хүн болох нөөц хөрөнгө буй гэж үзсэн, мөн түүнчлэн хүн ухамсар сэтгэл санаагаараа өөрийгөө удирддаг, тиймээс ганцхан амьдрах энэ насыг үр бүтээлтэй өнгөрөөхийг юм бүхний үндэс сэтгэл санааны үүднээс сануулан сургасан ажээ.

Дүгнэлт

Бясалгалын эгшиглэл хэмээн шүлэгт энгийн хүний амьдралд тохиолдох бэрхшээл, зовлонгоос хэрхэн ангижрах аргыг багшаас асууж, сэтгэлийн зовлон жаргал, тогтворгүй байдал, тулгамдсан асуудлуудаа яаж шийдэх вэ, гэдэг санаа дэвшүүлээд энэ насны баясгалант амьдрал, насны буурал, буй юм шиг, мөнх юм шиг амьдралыг санаж яваад, тэнгэр язгуурын багш, ном, хувраг гурван шүтээнээ ихэд огоорч мартсанаа гэмшин, мөнх бусын жам ёсыг дагах зайлшгүй ёсонг ятган сэнхрүүлсэн. Мөн түүнчлэн хоосон чанар гэж юм бүхэн мөнх биш чанартай гэдэг дорно дахины гүн ухааны үзлийг илтгэсэн шүлэг юм.

Noyon Khutugtu Ravjaa was a mahasiddha \majician\ of Tantric philosophy, especially a great expert and unequalled genius in Chod practice. He was unequally qualified for secret arts of mind and language by the power of his sublime views.

Ном зүй:

Байгалсайхан. С *Утга зохиол шинжлэл* УБ Baigalsaikhan. S Literary Semantics UB

Хэл зохиол судлал. ШУАХ *Хэл зохиолын хүрээлэн* УБ 1987 № 18 боть Studies of Language and Literature, Institute of Language and Literature, MAS, UB 1987 No. 18 Vol.

Ил товчоо сонин. 1998:03.23 №12\284 *Il Tobochoo newspaper* 1998:03.23 No. 12\284



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.